

МОНГОЛ ХЭЛНИЙ ДЭВСГЭРЛЭХ, ҮЛ ДЭВСГЭРЛЭХ ҮСГИЙН ТУХАЙ
болон
АКАДЕМИЧ Ш.ЛУВСАНВАНДАНЫ НЭГЭН ГАР БИЧМЭЛ

Б. Түвшинтөгс *

Монгол хэлшинжлэлийн сэтгэлгээ олон зуун жилийн түүхтэй бөгөөд тэр хирээрээ баялаг өв сан бий болгожээ. Ялангуяа монголчуудын уламжлалт хэлзүйн бичгүүд нь хэлшинжлэлийн сэтгэлгээний түвшинг тодорхойлон харуулах бодит гэрч болох тул тэдгээр бүтээлд тэмдэглэсэн нэртөмьёо, ойлголтыг зөв ухаарах, тайлбарлах нь монгол хэлзүйчдийн онолын сэтгэлгээг тодруулахад төдийгүй тухайн үеийн хэлшинжлэлийн онолын түвшний дунд эзлэх монгол хэлзүйчдийн байр суурийг тодорхойлоход ач холбогдолтой юм. Энэ талаар дотоод, гадаадын судлаачид цөөнгүй бүтээл туурвисан, ялангуяа академич Ш.Лувсанвандан монгол уламжлалт хэлзүйн бичиг дэх зарим ойлголтыг орчин цагийн хэлшинжлэлийн онолын үүднээс тодорхойлон тайлбарлаж тусгайлсан болон ташрамын бүтээл хэвлүүлснийг та бид сайн мэднэ¹.

Академич Ш.Лувсанвандан бүтээлүүддээ олонтоо онцлон тэмдэглэсэн уламжлалт хэлшинжлэлийн ойлголтын нэг нь монгол бичгийн дэвсгэрлэх болон үл дэвсгэрлэх үсгийн тухай асуудал боловч түүний бүтээлийн жагсаалтаас² үзвэл тэрбээр энэ талаар тусгайлсан өгүүлэл нийтлүүлээгүй бололтой. Харин бидний хойно сийрүүлэг болон эх зургаар нь хэвлүүлж буй баримтаас үзвэл тэрбээр монгол уламжлалт хэлзүйн бичгүүд дэх дэвсгэрлэх болон үл дэвсгэрлэх үсгийн талаар *Монгол хэлний дэвсгэрлэх, үл дэвсгэрлэх гийгүүлэгчийн тухай асуудалд* сэдэвт тусгай өгүүлэл бичиж Хэл зохиолын хүрээлэнгээс эрхлэн гаргадаг Хэл зохиол судлал [Studia Lingue et Literarum] цувралд хэвлүүлэхээр өгсөн бололтой³. Гэвч чухам юуны учир хэвлэгдэлгүй гар бичмэлээр

* ШУА, Хэл зохиолын хүрээлэн

¹) Энэ талаар дараах бүтээлээс дэлгэрүүлэн үзнэ үү: Үз: Д.Төмөртоого. *Академич Ш.Лувсанвандан бол уламжлалт хэл шинжлэлийг бүтээлчээр хэрэгжүүлэгч мөн* //SLL [Хэл зохиол судлал]. Т-ХII (20), fasc. 17. Уб., х.249-253

²) Монгол хэлшинжлэлийн төрөлжсөн номзүй болон академич Ш.Лувсанванданы бүтээлийн сүүл үеийн харьцангуй бүрэн жагсаалтаас хянан нягталсан болно. Үз: Б.Сумъяабаатар. *Монгол хэл, утга зохиол, аман зохиолын номзүй. Монгол хэл*. Уб., 1971, 380 х.; Б.Төвшинтөгс. *Хэл шинжлэлийн бүтээлийн номзүй (1971-2001)*. Ред. Л.Болд. Уб., 2001, 160 х.; Э.Пүрэвжав. *Их эрдэмтэн академич Шадавын Лувсанвандан*. Хян. Д.Төмөртоого, Д.Заяабаатар. Уб., 2010, х.124-145; Ж.Бат-Ирээдүй, Б.Түвшинтөгс. *Монгол хэлшинжлэлийн өгүүлэлзүй*. Уб., 2012, 410 х.

³) Ш.Лувсанванданы энэхүү өгүүллийн гар бичмэлд “шинэ өгүүлэл” хэмээн балын харандаагаар бас “1978.6.2” гэсэн огноог ягаан өнгийн бэхээр тус тус тэмдэглэсэн байна.

үлдсэн нь тодорхойгүй. Тиймээс бид хэдийгээр монгол бичгийн дэвсгэр үсгийн талаарх ойлголтод тулгуурлан монгол хэлний гийгүүлэгч фонемуудын байрлалыг тогтоосон Ш.Лувсанванданы үзэл онол түүний олон бүтээлд туссан байдаг ч ахмад судлаачдын эрдэм шинжилгээний ажлын өвийг судлах, бүрэн нийтлэх, зөв ойлгох, бүтээлчээр хөгжүүлэхэд нэмэр болохын үүднээс энэхүү гар бичмэлийг хэвлэн нийтлүүлж байгаа болно.

Ерөөс монгол хэлшинжлэл дэх дэвсгэрлэх болон үл дэвсгэрлэх үсгийн тухай асуудал нь монгол хэлний гийгүүлэгчийн байрлал, үеийн бүтэц, авианы харилцан нөлөөлөлтэй холбоотой, судлаачдын анхаарлыг зүй ёсоор татдаг сэдэв билээ. Уламжлалт монгол хэлзүйн дэвсгэрлэх болон үл дэвсгэрлэх үсгийн тухай ойлголт бидний үед XVIII зууны үеийн хэлзүйч равжамба Данзандагвын бүтээлээр уламжлан ирсэн боловч гийгүүлэгч фонемуудын байрлалыг тогтоосон энэ хуулийг тэрбээр анх нээсэн бус харин XIII-XIV зууны үед Гунгаажалцан, Чойжи-Одсэр нар анх үндэслэсэн гэж үзэж болох⁴ юм. Угтаа монгол хэлшинжлэлийн эртний бүтээлүүд нь Энэтхэг-Түвдийн хэл бичгийн ухаантай нягт холбоотой, түүний хүчтэй нөлөөн доор хөгжиж ирсэн тул энэхүү дэвсгэр үсгийн талаарх ойлголт ч мөн түвд бичгийн $\text{ᠠ ᠨ ᠠ ᠨ ᠠ ᠨ ᠠ ᠨ ᠠ ᠨ ᠠ ᠨ ᠠ ᠨ ᠠ ᠨ ᠠ}$ гэсэн 10 үсгийг тэмдэглэдэг “даган орогч” гэдгээс үүсэлтэй байж мэднэ⁵ хэмээсэн саналыг харгалзаж үзүүштэй, нарийвчлан судлууштай санагдана.

Монгол бичгийн зарим гийгүүлэгч заримдаа ардаа эгшиггүй, үеийн эцэст тохиолддог ба эдгээр нь **b, γ / g, r, s, d, m, n, ng, l, y, w** энэ 11 үсэг болно. Энэхүү 11 үсгээс орчин цагийн монгол хэлэнд **y, w**-ээс бусад 9 нь уламжлан иржээ. Тэгвэл чухам яагаад энэ хоёр үсэг юуны учир орчин цагийн монгол хэлэнд дэвсгэрлэн орохоо болив, угаасаа энэ хоёр үсэг дэвсгэр үсэг мөн байсан уу үгүй юу зэрэг асуулт урган гарч байна. Энэ асуудлыг доктор Д.Заяабаатар тусгайлан судлаад “...өнөөг хүртэл **y, w** дэвсгэр хэмээн хэлэлцсээр буй ойлголтын мөн чанар, хэвшил хэрэглээ, эш баримтыг нягтлан ажиглахад үе төгсгөн ордог байсныг нутлах баттай баримт олдохгүй байна. <...> уламжлалт хэлшинжлэлийн сурвалж бичгүүдэд

- Үгийн дундах “**y**” үе буюу хоёр шилбэ (ii Д.З.), мөн **y** гийгүүлэгчийн “орхиц”-ын өмнө тохиолдох **l** хэлбэр (**l** **T**) ба задгай үеийн хос эгшгийн бүрэлдэхүүн дэх “**i**” эгшгийг **y** дэвсгэр:

- Харь үгэнд ордог **w** (**W**) гийгүүлэгч үгийн эцэст тохиолдохдоо хэрхэн авиалагдах байдлыг тусгахын зэрэгцээ монгол бичгийн үндсэн үсэглэврээр тэмдэглэх журмыг тогтоосноос үүдэлтэй бий болсон **OT** цогцын **0** хэлбэрийг “**w** дэвсгэр” гэж үзэж байсныг хожмын эрдэмтэд янз бүрээр ухаж ойлгосны улмаас “арван нэгэн дэвсгэр үсэг” хэмээх зохиомол нэрлэлт монгол хэлний судлалд нэгэнтээ хэвшжээ.

Үүнээс улбаалж, “**w, y** дэвсгэр” гэдэгт элдэв жишээ оноож ирсэн нь монгол хэлний авианы түүхэн хувьслыг тайлбарлахад зарим талаар будлиан тарьсан бололтой. Өөрөөр хэлбэл, уламжлалт хэлшинжлэлийн зарим сурвалж бичгээс эхтэй үсэглэврийн хувилбарт холбогдох ойлголтыг авианы үзэгдэл болгон тайлбарласан нэгэн зүйлийн ташаарал байжээ. Өмнө дурдсан үзэл саналын үнэний хувь нь илүү аваас, монгол хэлний түүхэн хөгжлийн эрт үед **y, w** дэвсгэр гэж байсангүй бөгөөд ерөөсөө үе төгсгөн

⁴) Төмөртогоо Д. *Монгол хэлшинжлэлийн түүхэн уламжлал ба онолын үндэс* //Д.Төмөртогоо. *Монгол хэлшинжилэлийн онол, түүхийн асуудалууд*. Уб., 2002, х.416.

⁵) Балданжапов П.Б. *Jiruken-u tolta-yin tayilburi Монгольское грамматическое сочинение XVIII века*. Монгольский текст и перевод. Введение и примечания. Улан-Удэ. 1962, х.92.

ордог 9 гийгүүлэгч л байжээ гэдгийг дүгнэн хэлэх боломжтой байна. Тэдгээр 9 дэвсгэр гийгүүлэгч орчин цагийн монгол хэлэнд мөн адил хадгалагдаж байгаа бөгөөд *n, m, l, ng, b, γ/g, r, d, s* болно”⁶ хэмээн үзсэн байна. Үнэндээ энэ хоёр үсэг нь заримдаг байдалтай, өөрөөр хэлбэл өгүүлүүрзүйн хувьд эгшгээс гийгүүлэгч рүү шилжих завсарт байрладаг хагас эгшиг, хагас гийгүүлэгчийн шинжтэй бөгөөд үүслийн хувьд гийгүүлэгчээс эгшгийн шинж нь давамгайлах болжээ. Өөрөөр хэлбэл Дундад үеийн монгол хэлний хоёр эгшгийн дундах шүргэх гийгүүлэгчийн сулралтай холбоотой үзэгдэл⁷ юм.

Ш.ЛУВСАНВАНДАН

Монгол хэлний дэвсгэрлэх, үл дэвсгэрлэх гийгүүлэгчийн тухай асуудалд

Хуучин монгол бичиг дээр үндэслэсэн хэлзүйн бичиг зохиолд 11 дэвсгэр үсэг гэж байдаг. Энэ нь: *b, γ, g, r, s, d, l, m, n, η, v, y* болно. *χ, x, j, č* зэрэг нь дэвсгэр бус үсгүүд болно. Дэвсгэрлэх үсгүүд нь үеийн адагт орж болох гийгүүлэгчүүд, үл дэвсгэрлэх үсгүүд гэдэг нь үеийн эхэнд, зөвхөн эгшгийн өмнө ордог гийгүүл(эг)чүүдийг хэлнэ. Одоо энэ дэвсгэр [үсгүүд] орчин цагийн халх монгол хэлэнд байна уу, үгүй юу? байвал бүрэн байна уу, зарим нь байна уу, хэрэв зарим нь байвал ямар ямар гий-//гүүлэгч байна гэсэн асуулт бидний өмнө тулгарч байна. Дорно зүгт хятад, япон хэл хамгийн цөөн дэвсгэр гийгүүлэгчтэй юм. Тэр нь *n, η* хоёрхон болно. Тэгээд вьетнам, төвөд, монгол мэтийн хэл нь арваад арваад дэвсгэр гийгүүлэгчтэй байна. Орчин цагийн монгол хэлний дэвсгэрлэх үсгүүд нь *b, g, r, s, d, l, m, n, η* ес болно. Түрэк, *e[v]*роп зүгийн хэлэнд бүх гийгүүлэгч нь дэвсгэрлэж болох тул тэгэж хоёр хувааж болохгүй юм. Монгол хэлний дэвсгэрлэх гийгүүлэгчийн дотроос ганц *η* эгшгийн урьд орохгүй, үл дэвсгэрлэх гийгүүлэгчийн дотроос ганц *y* нь гийгүүлэгчийн өмнө орж болохгүй юм. Жишээлбэл: *g a᠋ᠣᠭᠠᠷ, āēld_χ* гэх мэт.

// Дэвсгэр гийгүүлэгчийг дотор нь чанга дэвсгэр *b, g, r, s, d*, сул дэвсгэр *l, m, n, η* гэж хоёр хуваадаг. Чанга дэвсгэр нь үгийн эцэст дуугүй, сул дэвсгэр нь дуутай хэлэгднэ. Чанга дэвсгэр үсгийн дотроос *b, g, r, d* нь угтаа заримдаг дуутай боловч үгийн эцэст дуугүй болно. Сул дэвсгэр нь үгийн эцэст дуутай хэлэгднэ. Жишээлбэл: *ḅ, ḡ, ṛ, ḏ, l, m, n, η* гэх мэт.

Дэвсгэрлэх, үл дэвсгэрлэх гийгүүлэгчийн хойно орсон балархай эгшгийг сонсоод ялгахад бэрхтэй байдаг боловч харьцаагаар нь хялбархан мэдэж болно. Хэрэв уг үг нь үйл үг байгаад дараа нь *-dži* нөхцөл, *-ül (-ül)*, *[-ga (-gə)]*⁸ дагавар авах байвал эгшиг, эсэхүл сул дэвсгэр гийгүүлэгчээр төгссөн, // *-tši* нөхцөл, *-ga (-gə)* дагавар авах байвал чанга дэвсгэр гийгүүлэгчээр төгссөн үйл үг байж, хэрэв нэр үг байгаад өгөх оршихын

⁶) Заяабаатар Д. Монгол хэлний “y”, “w” гийгүүлэгч дэвсгэрлэдэг байсан уу? //Acta Mongolica МУИС ЭШБ. Том. 5 (246). Уб., 2005, х.82-83.

⁷) Дундад үеийн монгол хэлний хоёр эгшгийн дундах шүргэх гийгүүлэгчийн сулралын талаар дараах бүтээлээс тодруулан үзнэ үү. Үз: Д.Төмөртогоо. Дундад үеийн монгол хэлний хоёр эгшигийн хоорондох шүргэх гийгүүлэгчийн сулрал //Mongolian Studies. Seoul. 1995, №3, х.219-224.

⁸) Өгүүллийн агуулга, авсан жишээнээс үзвэл энэ хэсгийг давхардуулсан бололтой.

тийн ялгалын $-d_{\lambda}$ ($-d_{\circ}$) нөхцөл авах байвал балархай эгшиг буюу сул дэвсгэр гийгүүлэгчээр төгссөн, $-t_{\lambda}$ ($-t_{\circ}$) нөхцөлийг нь авах байвал чанга дэвсгэр үсгээр төгссөн нэр үг байна. Жишээлбэл: $tat_{\lambda}d_{\lambda}zi$, $tat_{\lambda}ul$, $\text{ᠬ}ar_{\lambda}d_{\lambda}ᠵi$, $\text{ᠬ}ar_{\lambda}ul$, $x_{\lambda}urt_{\lambda}ᠰi$, $x_{\lambda}urg_{\lambda}ᠭ$, $g_{\lambda}ar_{\lambda}ᠰi$, $g_{\lambda}arg_{\lambda}ᠶ$, $t_{\circ}r_{\circ}d_{\circ}zi$, $t_{\circ}r_{\circ}ul$, $g_{\lambda}ar_{\lambda}t_{\lambda}$, $g_{\lambda}er_{\lambda}t_{\lambda}$, $ar_{\lambda}d_{\lambda}$, $er_{\circ}d_{\circ}$ гэх мэт. Бас салангид хэлэхэд дэвсгэр үсгийн эхэнд богино эгшиг нэмж дэвсгэр бус үсгийн ардхи богино эгшигийг урт болгож хэлнэ. Урт эгшгээр эхэлсэн нөхцөлийг дэвсгэр үсгээр (төгссөн) үгэнд шууд залгаж, дэвсгэр бус үсгээр төгссөн үгэнд г-гээр жийрэглэж залгана. Жишээлбэл: ew -ийн, ew - $\bar{e}r$, eg -ийн, eg - $\bar{e}r$, er -ийн, er - $\bar{e}r$, es -ийн, es - $\bar{e}r$, ed -ийн, ed - $\bar{e}r$, $t\bar{a}$ -гийн, ta -гаар, // $tᠰi$ -гийн, $tᠰi$ -гээр, $ts\bar{e}$ -гийн, $ts\bar{e}$ -г $\bar{e}r$, dzi -гийн, dzi -гээр, $dz\bar{e}$ -гийн, $dz\bar{e}$ -гээр, $\check{s}\bar{e}$ -гийн, $\check{s}\bar{e}$ -гээр, $y\bar{a}$ -гийн, $y\bar{a}$ -гаар, $g_{\lambda}\bar{a}$ -гийн, $g_{\lambda}\bar{a}$ -гаар гэж бас хоёр хувааж болно. Дэвсгэр үсгийн дотроос ганц η өөрийн чанараар г шаардана. Хуучин монгол бичигт v дэвсгэр гэдэг нь одоо урт $-ū$ ($-ū$) болж өмнөх богино эгшиг нь замхаран үгүй болсон, y дэвсгэр гэж байсны y сугаран үгүй болж, i нь өмнөх урт эгшигтэйгээ ижилшин хос буюу урагшилсан урт эгшиг болсон байна. Жишээлбэл: $\bar{a}yimaγ > \bar{a}imaγ > \bar{a}ēmāg$, $tevke > teūx_{\circ} > tōūx_{\circ} > tūūx_{\circ}$, $tavlai > taūlai > toūlai > tuūlai > tūlai$ гэх мэт.

// Орчин цагийн монгол хэлэнд чанга дэвсгэрээр төгссөн үгийн дараа өгөх оршихын тийн ялгалын $-t_{\lambda}$ ($-t_{\circ}$) хэлбэрийг хэрэглэсээр байна. Жишээлбэл: $arawt_{\lambda}$, $bagt_{\lambda}$, $g_{\lambda}ar_{\lambda}$, $zalūst_{\lambda}$ гэх мэт. Мөн үүнчлэн сул дэвсгэрээр төгссөн үгийн дараа гийгүүлэгч залгахад өгөх оршихын тийн ялгалын $-d_{\lambda}$ ($-d_{\circ}$) нөхцөл, үйл үгийн $-d_{\lambda}zi$ дагавар, $-ūl$ дагавары нь залгада(г) байсан хэвээрээ байна. Бас үл дэвсгэрлэх гийгүүлэгчээр төгссөн үгийн дараа дэвсгэрлэх, үл дэвсгэрлэх гийгүүлэгч залгахад заавал эгшиг шаарддаг нь үнэндээ эгшиг шаардаж байгаа биш нэгэнт байсан эгшиг нь тотрч [=тодорч] байгаа хэрэг юм. Энэ учраас дэвсгэр, дэвсгэр бус үсгийн тухай асуудал нь монгол хэлний ноцтой асуудал юм.

// Монгол хүн урьд, хойно нь байсан эгшигийг хэт балархай эгшигийн оронд гүйлгэж хэлэх заншилтай тул хойно нь эгшиг орвол d , s -ийн дараа хэлэхгүй d -ийн өмнө оруулж хэлдэг өнцхөн байдлыг үндэс болгосон байна. Гэтэл олон үет урт үгийн $-d$, $-s$ -ийн дараа $-t_{\lambda}$ ($-t_{\circ}$) хэлнэ. Жишээлбэл *улсад*, *эрсэд*, *морьдод* гэж хэлэх атал *залууст*, *удирдагчидт* гэх мэт. Үнэндээ $ulust_{\lambda}$, $er\check{e}st_{\circ}$, $mor\check{i}dt_{\lambda}$, $dzalūst_{\lambda}$, $ūdirdagtsid_{\lambda}$ гэж хэлж байна.

Гийгүүлэгч авиаг ингэж ангилах нь эгшиг, гийгүүлэгч хоёрын үндсэн дээр хувааж байгаа хэрэг юм. Гийгүүлэгч дэвсгэрлэх $\bar{e}c$ нь хэл бүрд адилгүй байгаагаас үзэхэд хэлний онцлог тул анхаарах асуудлын нэг юм.

// Монгол хар хэлний *стол* гэсэн үгийг 'остол' гэж хазгай хэлдэг нь монгол хэлэнд хоёр гийгүүлэгчээр эхэлсэн буюу төгссөн үе байдаггүй гэдэг нь үнэн бололтой. Дэвсгэрлэх, үл дэвсгэрлэх гийгүүлэгчийн тухай асуудал бол бас битүү үе, задгай үетэй шууд холбогдох асуудал болно. Монгол хэлний битүү үетэй, задгай үетэй үгийн хоорондын харьцаа, битүү, задгай үеийн эгшиг, гийгүүлэгчийн бүрэлдэхүүний харьцааг судлахад дэвсгэр үсэг тус болно. Монгол хэлэнд хоёр гийгүүлэгчээр эхэлсэн, төгссөн үе харь гаралтай үгэнд байдаг. Жишээлбэл: *bars*, *arslan*, *стол*, *гишин* гэх мэт.

// y гийгүүлэгчийг үгийн эхэнд нэ(г) урт шилбэтэй, үгийн дунд хоёр урт шилбэтэй, үгийн адагт i -тэй адил бичиж байжээ. Монголч эрдэмтэн үгийн дунд орсон хоёр урт шилбийн түрүүчийнхийг y , сүүлчийнхий нь i гэж галигладаг. Тэгвэл y гийгүүлэгч нь

өөр гийгүүлэгчийн өмнө нь, хойно нь орж болдоггүй, бас эгшгийн дараа орж болдоггүй, (эгшгийн өмнө), ардаа эгшигтэйгээр эгшгийн өмнө ордог гийгүүлэгч болж байна. Богино, урт эгшгийн аль алины дараа оровч урт эгшгийн дараа орвол у нь сугаран алга болж, хойтхи *i* нь өмнөх урт эгшигтэй ижилшиж хос эгшиг болдог ажээ. // Богино эгшгийн дараа *у* үе орвол у нь сугаран алга болдоггүй, хос эгшиг ч үүсэх[гүй,] хэвээрээ байдаг байна. Жишээлбэл: *поуан > поуи᠓, байан > байи᠓, хауидā, сайидā, оуидi, хеләуидē* гэх мэт. Энэ бүгдээс үзвэл у дэвсгэр байхгүй гэж үзэх нь зөв байна. Дөрвөлжин үсгээр *пооуi* гэсэн үгийн эцэст *у* бичиж байсныг үзэхэд хуучин монгол бичгээр *поqai* гэж бичиж байсны *i* нь *у* үеийн у сугарч *i* нь үлдсэний гэрч болно. Энэ учраас *i*-ийн оронд у бичиж болохгүй нь илэрхий байна. Жишээлбэл: *поqауi > поqai > пох᠔ē > пох᠔᠓* гэх мэт.

Дэвсгэр үсэг гэдэг нь үе төгсгөж чадах гийгүүлэгч, дэвсгэр болохгүй үсэг гэдэг нь үе үл төгсгөх гийгүүлэгч гэсэн үг болно. // Үе үл төгсгөх гийгүүлэгчид гэдэг нь үеийн эхэнд, эгшгийн өмнө орж чадах, үе төгсгөх гийгүүлэгчид нь үеийн эцэст орж чадах гийгүүлэгчдийг хэлнэ. Ингэж хуваах нь уул хэлний чанараас гарсан байна. Энэ учраас монгол хэлний дэвсгэрлэх, үл дэвсгэрлэх гэж хоёр хуваадаг нь заншил биш, ёс болно. Ер нь юм, үзэгдлийн чанар нь ганц хэлбэр, дүрсээрээ мэдэгдэхээс гадна мөн харьцаагаар мэдэгднэ. Энэ нь сайн хүн, муу хүн гэдэг нь царай зүсээр биш, явдлаар нь илэрхий байдагтай адил юм. // Жишээлбэл: *хар, гар* гэж хоёр үгийг адилхан *p*-ээр төгсгөж бичээд түрүүчийнхий нь балархай эгшигтэй, сүүлчийнхий нь балархай эгшиггүй гэдгийг сон[сгол]оор ялгахад хэцүү боловч *ᠬар᠋᠎a dʒi, g. aᠷᠲᠰi* гэж *-dʒi, -ᠲᠰi* залгаж болох, эсэх харьцаагаар ялгах мэт. Үүнд үл дэвсгэрлэх балархай эгшгээр, сул дэвсгэр гийгүүлэгчээр төгссөн үндсэнд *-dʒi* нөхцөл, чанга гийгүүлэгчээр төгссөн үндсэнд нь *-ᠲᠰi* нөхцөл залгадаг билээ. *Хар* гэсэн үгийг хойноо балархай эгшиг байхгүй гэж зүтгэдэг хүмүүс бол зөвхөн түүний хэлбэр, дүрсийг баримталж, харьцааг анхаа[раа]гүй болно. Гэтэл тийм хүмүүс нь хэлэхдээ алддаггүй *-dʒi* нөхцөлтэй хэлдэг нь // харьцаа хичнээн чухал болохыг харуулж байна. Балархай эгшиг нь энэ мэтээр чихэнд баригдахгүй атал харьцаанд баригдан мэдэгдэж байна. Үлигэрлэвэл, хар өнгөн дээр хараар, цагаан өнгөн дээр цагаанаар зурж чаддаггүй[тэй] адил юм. Өөр өнгөөр зурах нь харьцаагийн нь ил гаргах гэсэн санаа юм.

Үл дэвсгэрлэх үсгийн дараа ганц эгшиг залгадаг нь гийгүүлэгч, эгшиг хоршиж бүтсэн задгай үе үүсгэдэг гийгүүлэгч, дэвсгэрлэх үсгийн өмнө эгшиг ордог тул битүү үе үүсгэх гийгүүлэгч юм. Энэ учраас үл дэвсгэрлэх // гийгүүлэгч орсон үе нь задгай үе, дэвсгэрлэх гийгүүлэгч орсон үе нь битүү үе байна.

Орчин цагийн монгол хэлний үл дэвсгэрлэх гийгүүлэгчээр төгссөн үг бүхэн балархай буюу ямар нэг эгшгээр төгссөн, дэвсгэрлэх гийгүүлэгчээр төгссөн үг нь гийгүүлэгч буюу эсвэл балархай буюу ямар нэг эгшгээр төгссөн үг байна. Жишээлбэл: *tat, tatād, atši, atšād, maldʒi, maldʒād, šaši᠓, oᠬšōd, aᠬᠬ, aᠬār, eᠬᠬ, eᠬēr, baᠬ, baᠬār, eᠬ, ewēr, bag, bagār, eᠮ, ger, үrēs, үr, sēr, ᠬadd, ᠬadās* гэх мэт. *s, ᠬ, x, d* мэтийн дэвсгэр үсэг хоёр богино эгшгийн хооронд урт болж сунжирч хэлэгдэх боловч үгийн утгад холбогдолгүй. Жишээлбэл: // *aᠬᠬ, eᠬᠬ, nass, ᠬadd* гэх мэт. Ингэж сунжирч хэлэгдсэн гийгүүлэгчид нь урт, богино эгшгийн хооронд буюу хоёр урт эгшгийн хооронд дахин бичиж болно. Жишээлбэл: *axār, eᠬēr, nasārā, ᠬadār* гэх мэт. Орчин цагийн монгол хэлний

балархай эгшгийн ихэнхи нь дан ганц авиа салгах үүргэ гүйцэтгэж, олонхи нь утга ялгах үүргэгүй болж, цөөн хэд нь авиа салгах, утга ялгах үүрэгтэй нь хослон гүйцэтгэнэ. Жишээлбэл: dewes - dew_s, гэхэд түрүүчийн w, s хоёрын хооронд орсон e нь утга ялгахын хамт авиа салгасан, s-ийн хойно орсон e нь ганц // авиа салгасан үүргэтэй байна. Үл дэвсгэрлэх гийгүүлэгчийн ард орсон үгийн эцсийн балархай эгшиг нь ганц авиа салгавч утга ялгадаггүй балархай эгшиг байна. Жишээлбэл: bat_᠎, atši, arts_᠎, adži, adz_᠎, baḡši, agi, baᠭ_᠎ гэх мэт. Дэвсгэрлээгүй орсон дэвсгэрлэх гийгүүлэгчийн дараахи үгийн эцсийн балархай эгшиг ч бас ганц авиа салгаад, утга ялгах үүргэгүй байна. Жишээлбэл: taw_᠎, ḡar_᠎, nas_᠎, ḡad_᠎ гэх мэт. Үгийн утга ялгах балархай эгшиг нь хааяа үгийн дунд орсон битүү, задгай үеийн балархай эгшигт тохиолдоно.

ABSTRACT

This article presents a transcription and commentary on a manuscript article by Sh. Luvsanvandan concerning Mongolian-language consonants that require or do not require a succeeding vowel. In the orthography of the classical Mongolian script there are 11 consonants known as "devsger", which do not require a succeeding vowel; in contemporary Mongolian there are nine such consonants (b, g, r, s, d, l, m, n, and ᠨ). Although Luvsanvandan's position-based theory of Mongolian-language consonants is discussed in many of his other works, this manuscript will be of value to scholars wishing to study, compile, and appreciate the scholarly works and legacy of this great scholar.

Ш. Абуважвандаг. 1811
 Монгол хамгийг зөвсүрээх,
 урвараар хаагчдын
 тухай асуудал
 Хүрээний мөчөл бэлтгэлээр үндэстэн
 Хэвцэн бүтээгдэхүүн зөвсүрээх,
 энэ байдал. Энэ нь: в, г, д, е, з, ү, ш,
 и, о, ы, я болон х, ж, ё, ү зэрэг нь бөвөг
 байх чагын болно. Энэ зэрэгээр үндэстэн
 нь үеийн агаар мөчөл бүтээгдэхүүн
 нь бөвөгээр чагын үеийн
 агаар мөчөл бүтээгдэхүүн үндэстэн
 нь үеийн агаар мөчөл бүтээгдэхүүн
 бөвөгээр чагын үеийн бөвөгээр чагын
 үеийн агаар мөчөл бүтээгдэхүүн үндэстэн
 бөвөгээр чагын үеийн бөвөгээр чагын
 үеийн агаар мөчөл бүтээгдэхүүн үндэстэн